




3-5 нас

ХҮҮХДЭД зориулсан зурган библи

Бүтээлч ном

Хуучин гэрээ
2



Хүүхдэд зориулсан зурган библи

Бүтээлч ном **Хуучин гэрээ 2**

3-5 Нас

Эмхэтгэсэн

|  kidsworship

 Selah
Ministry of Christian Publishing

Орчуулагч | N.Soninbayar, Н. Сонинбаяр График дизайнер | Jeewon Park, Julio Blas Засварласан | N.Soninbayar, Н. Сонинбаяр

Энэ номыг зохиогчын зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлахыг хориглоно.

ГАРЧИГ



1. Иаков 3	6
2. Иосеф 1	9
3. Иосеф 2	14
4. Мосе 1	17
5. Мосе 2	22
6. Мосе 3	26
7. Иошуа	30
8. Гидеон ба гурван зуун цэрэг эрс	33
9. Самсон	37
10. Даруу бэр Рут	41






Миний ахиц дэвшил



Тухайн библийн түүхийг үзэж дуусгасны дараа библийг өнгөөр ялган будаарай.



QR кодыг
уншуулан дараах
видеог үзээрэй.



Түүх 1 : Иаков 3

Библийн эшлэл
[Эхлэл 33:106]

Тэгээд ч тантай нүүр тулах нь Бурхантай нүүр тулах мэт ажээ.
Та ч намайг таалсан билээ.


Иаков төрсөн нутгаасаа гараад 20 жил өнгөрчээ. Тэрээр төрсөн нутгаа маш ихээр санаж байв. Нэгэн өдөр Иаков шийдвэр гарган өөрийн өмч хөрөнгөө таслан авч төрсөн нутгаа зорин явав. Гэртээ ойртох тусам Иаковын санаа нь ихэд зовж байв. Тэрээр ах Есаваасаа маш их айж байлаа. Иаков эхлээд өөрийн зарц нараа ах Есав уруугаа явуулав. Хэсэг хугацааны дараа зарц нар нь Иаков дээр ирээд хэлэв. “Таны ах Есав, 400 хүнээ дагуулан тантай уулзахаар ирж байна.” Зарцын хэлсэн үгийг сонсоод ах Есав нь ихэд ууртай ирж яваа байх гэж бодон Иаков маш их айж байв. Иаков эхлээд гэр бүлийнхнийгээ явуулж, мөн зарц нартаа даатган ахдаа бэлэг сэлт бэлдүүлэв. Есав ах нь өөрийг нь алчихаж магадгүй гэсэн бодлоосоо болж Иаков хамт явж чадахгүй байв. Тэр өдрийнхөө орой Иаков ганцаараа санаа зовон сууж байлаа. Гэнэт хаанаас ч юм нэгэн хүн гараад ирэв. Тэр бол Бурханы илгээсэн тэнгэр элч байлаа. Харин Иаков шөнөжингөө Бурханы илгээсэн тэнгэр элчтэй барилджээ.


Гэхдээ Иаков ялагдахгүйн тулд ноцолдсоор байв. Үүр цайх үед тэнгэр элч ингэж хэлэв.

“Энэ цагаас эхлэн чамайг Израиль гэж дуудах болно.” гэв.

Тэнгэр элч түүнийг орхин явав. Иаков ахтайгаа уулзахаар очиход ах нь түүний бодсоноос огт эсрэгээр, дүүгээ найрсагаа угтан халуун дотноор тэврэн авчээ.

Ингэж олон жилийн дараа ах дүү хоёр уулзжээ. Тэд бие биенээ тэврэн, хамтдаа уйлалдав. Аавынхаа ерөөлийг мөн Бурханы ерөөлийг хүртсэн Иаков их баян хүн болж төрсөн нутагтаа буцан иржээ.





- Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Эхлэл 33:106)

Та ч намайг таалсан билээ.

